УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2020 оны 06 сарын 11 өдөр Дугаар А/196. Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны 2020 оны "Үндэсний их баяр наадам, зохион байгуулах зардлын төсөв, түр журам батлах тухай" 02 дугаар тогтоол, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний их баяр наадмыг "13-р зуун цогцолбор", "Хүй долоон худаг"-т зохион байгуулахтай холбогдуулан тохижилт, гэрэлтүүлэг, худаг, хог хаягдал, ариутгал халдваргүйтгэл, нийтийн бие засах газар, угаалтуур, хог хаягдлын үйлчилгээний бэлтгэл ажлыг хангуулж, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	С.Аригуун	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд:	Б.Цэрмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Ахлах нягтлан бодогч
	Р.Даваасүрэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн Цахилгаан хангамж, гэрэлтүүлэг, холбооны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
	Б.Мөнхжаргал	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтсийн Хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Б.Мөнхбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтсийн Хөрсний бохирдол хариуцсан мэргэжилтэн

2. Бэлтгэл ажлын хүрээнд гүйцэтгэгч байгууллагуудтай гэрээ байгуулан, гүйцэтгэлд хяналт тавьж, ажлын явц үр дүнг тогтмол мэдээлж ажиллахыг Ажлын хэсэг /С.Аригуун/-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

c:\users\gantuya\desktop\үж 12\doc 2020\тушаал 2doc.docx

1110300726